

Тэмцээний дотоод журам

- Тэмцээн Swiss team системээр 8 өрөг тоглоно.
- Нэг талдаа 15 минут буюу нийлээд 30 минутын цагийн хяналттай тэмцээн явагдана.
- Багуудын ирсэн мэдүүлгийн дагуу шүүгч Баг болон багийн гишүүдийн нэрсийг шивж 2025 оны 3 сарын 22 – ны 20:00 цагт нэрсийг **Chess results Mongolia** сайтруу оруулна.
 - Багийн ахлагч нар **Chess results Mongolia** сайтруу орж өөрсдийн мэдүүлгийг заавал шалгаж өгсөн мэдүүлгээс алдаатай байвал шууд холбогдож хэлнэ.
 - **Chess results Mongolia** сайтруу нэрс орсны дараа багийн мэдүүлгийг огт засахгүй бөгөөд гишүүдийг өөрчлөх боломжгүй.
- Багуудийн өгсөн мэдүүлгийн дагуу 1-р ширээ дээр тоглох тамирчин заавал 1-р ширээн дээр 2-р ширээн дээр тоглох тамирчин заавал 2-р ширээн дээр 3-р ширээн дээр тоглох тамирчин заавал 3-р ширээн дээр тоглоно. Тамирчид ширээгээ сольж тоглохыг хатуу хориглоно.
- Тэмцээн 2025 оны 3 сарын 24-ны 10цагт эхэлнэ.

Цагийн хуваарь

| | |
|-----------|-------------|
| 1-р өрөг | 10:00 |
| 2-р өрөг | 10:40 |
| 3-р өрөг | 11:20 |
| 4-р өрөг | 12:00 |
| Цайны цаг | 12:30-13:30 |
| 5-р өрөг | 13:30 |
| 6-р өрөг | 14:10 |
| 7-р өрөг | 14:50 |
| 8-р өрөг | 15:30 |

- Тэмцээн цагийн хуваарийн дагуу явагдах учир тамирчид цагаа сайн баримтлахыг хүсэж байна. Тэмцээн эхлэхэд тамирчид ирээгүй тохиолдолд эсрэг багийн тоглогчид цагийг дарж өрсөлдөгчийг хүлээхийг анхаарна уу!
- Эцсийн дүн багийн авсан оноогоор гарна.
(Хожил – 2 оноо Тэнцвэл – 1 оноо хожигдвол – 0 оноо)
- Хоорондын хожил таслах тухай.
 1. Хоорондын хожил
 2. Бухгольц 2023 (энэ нь тоглосон тоглогчдын онооны нийлбэр коэффициент юм)
- Тамирчид өрсөлдөгч болон шүүгчидтэй ёс бус харьцахыг хатуу хориглоно. Тэгсэн тохиолдолд сануулгын арга хэмжээ авч түүнээс цаашилж багийг хожигдол хүлээлгэхэд хүргэнэ.
- Дууссан тамирчид тэмцээний заалийг чөлөөлнө.
Дасгалжуулагч тэмцээн эхэлсэн цагт тэмцээний заалийг чөлөөлнө.
Шүүгчийн шаардлагыг хүлээж авахгүй бол сануулгын арга хэмжээ өгнө. Мөн цаашлаад хожигдол хүлээлгэнэ.
- Дууссан тоглогч заавал шүүгчдээ дүнгээ тэмдэглүүлнэ.
- Ямар нэгэн асуудал гарвал цагаа зогсоогоод шүүгчидээ хандана. Асуудал гарж шүүгчдээ хандахгүй өөрсдөө асуудлаа шийдсэн эсвэл цааш үргэлжлүүлэн тоглосон тохиолдолд тэр асуудлыг хүлээн авахгүй болно.